

Бодгальд минь дайсанд өгөх зай үгүй

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Жеффри Р.Холланд

Хайр болон гэрлэлтээ мөн нийгэм болон оюун санаагаа цэвэр ариун, байх ёстой байдлаар нь хадгалснаар өөрсдийн дотор орших хамгийн эрхэм, хамгийн зөв зарчимд үнэнч байсны баяр баясгалан биднийх байх болтугай.

Холланд эгч бид хоёрыг холын нэгэн онгоцны буудалд буух үед бидэнтэй нэг нислэгээс буусан үзэсгэлэн гоо гурван залуу эмэгтэй мэндлэхээр яаран ирж билээ. Тэд өөрсдийгөө Сүмийн гишүүд гэж танилцуулав. Энэ нь тийм гайхмаар зүйл биш л дээ, Яагаад гэвэл манай сүмийн гишүүн биш хүмүүс онгоцны буудал дээр тэгж бидэн уруу яарч ирдэггүй. Төлөвлөөгүй энэ ярианы үеэр гурван эмэгтэй гурвуулаа саяхан нөхрөөсөө салсан тухайгаа нулимс цийлэгнүүлэн ярив. Гурвуулангийнх нь нөхрүүд эхнэртээ үнэнч биш байсан гэнэ. Гэр бүл салалт болон нүгэл хилэнц нь порнографт дуртай болсноор эхэлжээ.

Өнөөдөр хэлэх үгээ энэхүү гунигттай түүхээр эхлэхэд надад амаргүй л байна. , “Үлэмж энхрий болоод ариун мөн эмзэг мэдрэмж бүхий тэдгээрийн ... өмнө би ... яриандаа маш шулуун байдлыг хэрэглэх ёстой болов, энэ нь намайг гонсойлгож байна”<sup>1</sup> гэж хэлсэн эртний Иаковын адил санагдаж байна. Гэсэн ч шулуун байх хэрэгтэй болоод байна. Би аав, өвөө хүн болохоор ч тэр үү, тэдний нүдэн дэх нулимс нь миний болон Холланд эгчийн нүдэнд нулимс цийлэгнүүлж, тэдний асуултууд намайг эргээд дараах асуултуудыг өөрөөсөө асуухад хүргэсэн юм. Яагаад бидний эргэн тойронд ёс суртахууны ийм их ялзрал бий болов? Яагаад

өчнөөн олон хүмүүс, гэр бүлүүд, түүний дотор Сүмийн зарим гишүүд, гэр бүл үүнд өртөгдөж, эмгэнэлтэйгээр хохирох болов ?

Гэвч мэдээж, би асуултынхаа хариултынх нь ядаж заримыг нь мэдэж байсан л даа. Ихэнх өдрүүдэд ямар нэгэн ёс бус мэдээлэл оюун санааг маань тал бүрээс довтолхыг бид бүгд олж мэддэг. Кино, телевизор, харанхуй бүдүүлэг дуу хөгжим, доромжлолын үгс болон садар самуун улам бүр газар авч, улаан цайм болж байна. Харамсалтай нь гэр бүлийнхээ түүхийг бичиж, Ариун сүмийн ёслолд олон нэрс бэлтгэхэд хэрэглэдэг өөрийн компьютер болон интернэтэд шүүлтүүр, хяналт тавихгүй бол оюун санааг нь үүрд эрэмдэг зэрэмдэг болгох олиггүй муухай дүр зураг, санаа бодлыг хүүхдүүд, ач зээ нарт минь бүдүүлгээр тулгаж байна.

Сайхь залуу эхнэрүүдийн нөхрүүдийнх нь үнэнч бус явдал порнографт дуртай болсноор эхэлснийг санагтун. Гэвч энэ садар самуунд уруу татагдаж, үйлддэг нь зөвхөн эрчүүд болон нөхрүүд биш юм. Компьютерийн ганц товчлууур дарахад бидний нүдний өмнө аюул гамшиг гарч ирдэг бөгөөд интернетийн чат өрөөнд болж байгаа зүйл эрэгтэй,эмэгтэй, залуу, хөгшин, гэрлэсэн эсвэл ганц бие хэнийг ч ялгаварладаггүй юм. Дайсан уруу таталтыг улам хүртээмжтэй, хаалт саадгүй болгохын тулд өөрийн нөлөөгөө гар утас, видео тоглоом, MP3 тоглуулагч зэрэгт тэлж, үүнийгээ бизнес хэмээн нэрлэж байна.

Хэрэв бид энэ асуудлын мөчрийг нь тас цавчиж хаяхын оронд модны үндэс уруу нь шууд довтолвол шунал тачаал энэ асуудлын үндэс болж байгааг олж мэдэх нь гайхмаар зүйл биш юм. *Шунал тачаал* гэдэг эвгүй муухай үг бөгөөд ярилцахад ч эвгүй сэдэв юм. Гэвч зарим улс оронд үүнийг “үхэл мөхөлд хүргэдэг долоон

нүглийн”<sup>2</sup> хамгийн аймшигтай нь гэж үздэг нь цаанаа учиртай юм.

Шунал тачаал яагаад “аюултай” байдаг вэ? Энэ нь Ариун Сүнсийг биднээс холдуулснаар оюун санааг маань мөхөөхийн хамт, мөнх бус энэ амьдралд Бурханаас бидэнд өгсөн хамгийн эрхэм, ариун нандин харилцааг бузарладаг нүгэл мөн гэж би боддог. Энэ харилцаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биеэ хайрлах хайр, мөнхийн байж болох гэр бүлдээ үр хүүхэдтэй байх хүсэл юм. Жинхэнэ хайр нь хэзээ ч өөрчлөгдөж хувирдаггүй үзэл санааг өөртөө агуулсан байх ёстой гэж хэн нэг нь хэзээ ч юм бэ хэлсэн байдаг. Жинхэнэ хайр үүрд үл цөхөрнө. Харин порнографтай сэтгүүлийн хуудсыг эргүүлэхтэй адил, аль эсвэл өөр ямар нэг өөр зүйл, эрэгтэй, эмэгтэй хүн хажуугаар өнгөрөхийг хальт харахтай адил шунал тачаал нь асар хурдан өөрчлөгддөг. Жинхэнэ хайр үнэхээр сэтгэл догдлом зүйл. Бид хайр сэтгэлийнхээ тухай тэнгэрт тултал магтан дуулах дуртай. Жишээ нь гэвэл, Холланд эгчийн тухайд би ингэдэг л хүн. Харин шунал тачаал байгаа цагт ичгүүр нүүрээ өнгөлөн далдалж, нуугдмал байдалд ордог болохоор хяналт тавих бараг боломжгүй байдаг, Ингэхлээр цаг орой болж, харанхуй болох тусам юмыг яаж мэдэхэв хаалгаа давхар түгжих нь найдвартай мэт санагддаг. Хайр нь биднийг өөрийн эрхгүй Бурхан болон бусад хүмүүст хандахад хүргэдэг. Шунал тачаал бурханлиг байдлаас бүр ч хол, өөрийгөө өөгшүүлэн дэвэргэж, аминч үзлийг магтан дуулдаг юм. Хайр нь сунгасан гар, нээлттэй зүрх сэтгэлээр ирдэг бол, шунал тачаал зөвхөн сувдаг шунахай сэдэлтээр ирдэг.

Эдгээр нь бодож төлөвлөсөн эсвэл бодит хүн дээр хайрын үнэн утга учрыг бохир заваан болгодог олон шалтгааны зөвхөн ганц хоёрхон нь юм. Энэ нь бараг Бурханд итгэх бидний итгэл лүгээ адил амин чухал хайртай хүмүүстээ итгэх итгэлийг маань

мөхөөн сүйрүүлдэг юм. Энэ нь бидний одоогийн болон ирээдүйн хайрын суурь болох итгэлийн үндсийг сулруулдаг. Энэхүү итгэл нэгэнт алдарвал дахин бий болгоход маш их цаг хугацаа шаарддаг. Бидний гэр бүлийн гишүүн эсвэл олон нийтийн сонгогдсон албан тушаалтнууд, бизнесийн удирдагчид, алдар нэр нь цуурайтсан одууд алдартай тамирчид эсвэл хэний ч хувьд энэ асуудал хурцдахад удалгүй ёс суртахууны үүрэг хариуцлагатай нийгмийг цогцлуулахаар барих байшин дээр “Энэ байшин хоосон”<sup>3</sup> гэсэн тэмдэг хадахад хүргэх болно.

Бид ганц бие ч бай, гэрлэсэн ч бай, настай эсвэл залуу ч бай ямар ч байдлаар бидэнд ирэх эдгээр уруу таталтаас өөрсдийгөө хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй талаар товчхон ярья. Бид нийгмийн бүх өвчнийг эдгээж чадахгүй ч засч залруулж болох хувийн зарим нэг үйлдлүүдийн талаар ярилцъя.

Юуны түрүүнд та нарыг хорлох хүмүүс, материал болон орчингоос өөрсдийгөө хөндий байлга. Архинаас гарахын тулд тэмцэж буй хүмүүс гэм нүгэлд ойртох нь мөхөх аюултайг мэддэг. Энэ нь бас ёс суртахууны асуудал юм. Иосеф Потифарын эхнэрээс<sup>4</sup> зугтсаны адил та нарыг хуурч мэхлэн өөртөө татах хэнээс ч, юунаас ч чадлынхаа хэрээр аль болох хол зугт. Уруу таталтын газраас зугтахдаа очих газрынхаа хаягийг бүү орхиорой.

Хортой зуршил болон донтолтын гинжинд хүлэгдсэн хүмүүст өөрөө хийж чадахаас бүр илүү их тусламж хэрэгтэй байдаг. Энэ тусламж нь та байж болно шүү дээ. Энэ тусламжийг эрэлхийлж, хүлээн зөвшөөр. Бишоптойгоо ярилц. Зөвлөгөөг нь дага. Санваарын адислалыг хүс. Сүмийн Гэр Бүлийн Хөтөлбөрийн тусламжийг ашигла

эсвэл тохиромжтой мэргэжлийн тусламжийг хай. Тасралтгүй залбир. Тэнгэр элчүүдээс өөрсдөдөө туслахыг гуй.

Компьютерт шүүлтүүр тавьж, хүсэл тачаалаа цоожилсонч, амьдрал дахь цорын ганц үнэн бодитой хяналт бол өөрийгөө хянах явдал гэдгийг санагтун. Өөрсдөдөө тохиолдох сэжигтэй мөчүүдэд илүү анхаарал тавьж сур. Телевизийн шоу ёс жудаггүй байх юм бол зурагтаа шууд унтрааж бай. Кино ой гутам бүдүүлэг байвал орхиод гар. Зохисгүй харилцаа бий болж магадгүй байвал энэ харилцааг хурдхан орхи. Наанадаж л эдгээр нөлөөний олонх нь эхэндээ хор уршигтай биш юм шиг санагдаж болно. Гэвч бидний шийдвэрийг өөрчилж, сүнслэг байдлыг сулруулж, хор уршигтай муу зүйл уруу биднийг хөтөлж мэднэ. Мянган бээрийн аялал нэг алхмаар эхэлдэг<sup>5</sup> гэсэн хуучны нэг сургаал үг байдаг. Тиймээс алхмаа хянагтун.

Шөнийн хулгайч лугаа адил зохисгүй бодол бидний оюун санаанд орж мэднэ. Ийнхүү орж ирэхийг завдах нь бий. Гэвч бид ийм бодол санаанд хаалгаа нээн өгч, цай, бингээр үйлчилж, алт мөнгөө хаана хадгалдгаа хэлэх шаардлагагүй. (Та нар ерөөсөөө цайгаар үйлчлэх ёсгүй шүү дээ.) Луйварчинг хөөж гарга. Ёс жудаггүй бодол санаагаа итгэл найдварын төсөөлөл, аз жаргалтай дурсамжаар соль. Гомдоовол мөхөл сүйрэлд хүрч мэдэх, чамайг хайрладаг хүмүүсийн нүүр царайг төсөөл. Өөрийг тань хаа нэгтээ гэртээ хүлээж буй хүүхдээ, эсвэл эхнэрээ, эсвэл ээжийгээ санаснаар тэнэглэл, эвгүй байдал болон гэм нүглээс аврагдан зайлсхийж чадсан эрэгтэй хүн зөндөө бий. Та нарын зүрх сэтгэл дэх ямар ч бодол санаа зөвхөн “урилгаар” ирсэн байхыг мэд. Эртний нэгэн яруу найрагчийн хэлснээр хүсэл эрмэлзэл чинь чамайг өдөөх учир шалтгаан байг.<sup>6</sup>

Ариун Сүнсийг эрэлхийлж, Их Эзэний Сүнс байдаг газарт бай. Гэр орон чинь, байдаг газар чинь ийм байх хэрэгтэй. Гэр орон, байдаг газарт чинь ямар зураг, ямар хөгжим, уран зохиол байх ёстойг сайтар бод. Хэрэв чи хишиг хүртсэн бол, нөхцөл байдлаасаа шалтгаалан Ариун Сүнд аль болох олон удаа явж бай. Ариун Сүндг “[Бурханы] сүр хүч, [Түүний] алдар суу, [та нарын] эргэн тойронд байж, [Түүний] тэнгэр элчүүд [та нарын] дээр захирч<sup>6-7</sup> байдгийг санагтун. Ариун Сүмээс гарч явахдаа хүлээн авсан бэлгэдлийг сана. Тэдгээрийг хэзээ ч хойш тавьж, мартаж болохгүй.

Аюулд өртсөн хүмүүсийн ихэнх нь, “Би юугаа бодож байсан юм бол” хэмээн уйлдаг. Тэд юу ч бодож байсан, ямар ч гэсэн Христийн тухай бодоогүй нь лавтай. Гэвч Түүний Сүмийн гишүүд бид бүх амьдралынхаа туршид бүтэн сайн өдөр бүр Түүний нэрийг өөрсөд дээрээ авахаар ам тангараг өргөж, “үргэлж түүнийг санахаа”<sup>8</sup> амладаг. Иймээс Түүнийг санахаар арай илүү хичээцгээе. Ялангуяа Тэрээр “бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даасан...Тэр бидний нүглийн төлөө хатгагдсан...Түүний шархаар бид эдгэсэн”<sup>9</sup> гэдгийг [санагтун]. Бид нүгэл хийх бүрдээ хайртай хүмүүсээ гомдоогоод зогсохгүй бидэнд туйлын хайртай Түүнийг бас гомдоодог гэдгийг санах нь бидний үйл хэргийг эрс өөр замаар удирдах болно. Гэвч бид нүгэл үйлдвэл, мөн нүгэл нь хэчнээн ч ноцтой байсан тэрхүү Аугаа Хүнээр дамжин бид аврагдаж чадна. Тэнгэрийн доор өгөгдсөн цорын ганц нэрийг тээгч Түүгээр дамжин *ямар ч* эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд аврагдаж чадна.<sup>10</sup> Бид нүглээ хүлээж, бие сэтгэл маань үнэн шаналлаар зовон тарчилсан үед нүглээ наманчилсан Алмагийн, “Ай Есүс, Бурханы Хүү та намайг нигүүлсээч”<sup>11</sup> гэсэн чин сэтгэлийн үгс амьдралыг нь өөрчилсөн тэрхүү залбирлыг чангаар давтан хэлцгээе.

Ах эгч нар аа, би та нарт хайртай. Ерөнхийлөгч Томас С.Монсон болон Ах нар та нарт хайртай. Хамгийн чухал нь, та нарт Тэнгэрлэг Эцэг тань хайртай шүү. Би өнөөдөр энд хайрын тухай, жинхэнэ, үнэн хайрын тухай, хайрыг эрхэмлэн дээдлэх тухай, хүн төрөлхтний мэдэх эрүүл саруул нийгэмд хайр зүй ёсны хүндтэй байр эзэлж байсан тухай; энэхүү хайраас үүсэлтэй гэр бүлүүд болон гэрлэсэн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох ариун нандин харилцааны талаар; Христийн ач ивээлээр бидэнд ирдэг энэрлийн амьд биелэл болсон хайрын гэтэлгэгч мөн чанарын тухай ярихыг хичээлээ. Би мөн харгис хэрцгий нэгэн, худал хуурмаг, шунал тачаалын эцэг *Чөтгөрийн* тухай, тэрээр үнэн хайртай учирсан үедээ үүнийг гутаан бузарлаж, энэ бүхнийг хуурамчаар үйлдэхийн төлөө юу ч хийхээс буцахгүй болсон түүний тухай ярих хэрэгтэй байлаа. Ингэснээр тэр биднийг сүйрүүлэх хүсэл өвөрлөж явдаг тухай би бас ярьсан.

Бид өнөө үед ийм уруу таталттай учирсан үедээ залуу Нифайн адил “Би бодгалийн минь дайсанд дахин ... зай [тавих минь үгүй]”<sup>12</sup> хэмээн тунхаглах хэрэгтэй. Бид тэр чөтгөрийг эсэргүүцэж чадна. Хэрвээ бид үүнийг гүн гүнзгийгээр, бүр маш ихээр хүсэж байгаа бол, тэрхүү дайсан, Их Эзэн Есүс Христийн гэтэлгэлийн хүчээр зэмлэгдэж чадна мөн зэмлэгдэх болно. Мөн цаашид амьдрал чинь ямар ч найдлагагүй болж, ямар ч тусламжгүйгээр харанхуйд орхигдсон хэмээн айж байсан ч амьдралыг тань Түүний мөнхийн сайн мэдээний гэрэл гэгээ дахин тод томруунаар гэрэлтүүлж чадна, гэрэлтүүлэх ч болно гэдгийг би амлаж байна. Бид хайр болон гэрлэлтээ мөн нийгэм болон оюун санаагаа цэвэр ариун, байх ёстой байдлаар нь хадгалснаар өөрсдийн дотор орших хамгийн эрхэм, зөв зарчимд үнэнч

байсны баяр баясгалан биднийх байх болтугай. Есүс Христийн нэрээр залбирлаа,  
амен.

## ЭШЛЭЛ

1. Иаков 2:7.
2. Жишээлбэл Хенри Фейрли *The Seven Deadly Sins Today*(1978)-г үз.
3. Фейрлигийн, *The Seven Deadly Sins Today*, 175-ыг үз.
4. Эхлэл 39:1-13-ыг үз.
5. Lao Tzu, in John Bartlett, comp., *Bartlett's Familiar Quotations*, 14th ed. (1968), 74..
6. Lao Tzu, in John Bartlett, comp., *Bartlett's Familiar Quotations*, 14th ed. (1968), 74.
7. Сургаал ба Гэрээ 109:22.
8. Сургаал ба Гэрээ 20:77 мөн шүлэг 79-ийг үз.
9. Исаиа 53:4-5.
10. Үйлс 4:12-ийг үз
11. Алма 36:18.
12. 2 Нифай 4:28.